

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2008 ОНЫ  
САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**


**УЛААНБААТАР ХОТ  
2009 ОН**

## ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2008 ОНЫ САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Монгол улсын даатгалын салбарт 2007 оны байдлаар 15 компани ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан даатгалын гэрээний үндсэн дээр даатгуулагчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хариуцлагыг тохиолдож болзошгүй эрсдэлүүдээс даатгаж байсан бол 2008 онд урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулахаар 1 компани тусгай зөвшөөрөл авснаар нийт 16 даатгалын компани, 4 даатгалын зуучлагч, 1167 даатгалын төлөөлөгч, 9 актуарч үйл ажиллагаа явууллаа (Зураг-1).

Зураг - 1



Тайлант онд даатгалын компаниудад давхардсан тоогоор сайн дурын ердийн даатгалын 265 хэлбэрээр тусгай зөвшөөрөл олгосноос 45,3 хувь буюу 120 нь эд хөрөнгийн, 37,7 хувь буюу 100 нь хариуцлагын, 11,7 хувь буюу 31 нь амь нас, эрүүл мэндийн, 5,3 хувь буюу 14 нь санхүүгийн даатгалын төрөлд хамаарагдаж байлаа (Зураг-2). Эдгээр даатгалын хэлбэрүүдээс “Монгол даатгал” ХХК даатгалын 39 хэлбэрээр тусгай зөвшөөрөл авч даатгалын салбарын хэмжээнд тэргүүлсэн бол “Ганзам даатгал” ХХК даатгалын 7 хэлбэр буюу хамгийн цөөхөн даатгалын хэлбэрийн тусгай зөвшөөрөл авсан байна.


Тусгай зөвшөөрөл авсан сайн дурын ердийн даатгалын хэлбэрүүдийн бүтэц, дэд ангишлаар, 2008 оны байдлаар



## II. ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН ХӨРӨНГӨ

Даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын хөрөнгийн нийт хэмжээ 2008 онд 34,3 тэрбум төгрөгт хүрч өмнөх 2007 оныхоос 20,8 хувиар буюу 5,9 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ (Зураг-3). Даатгагчдын хөрөнгийн хэмжээний өөрчлөлтийн хандлагыг сүүлийн 6 жилийн байдлаар харахад 2006 оныг эс тооцвол тогтвортой өсч 2,7 дахин нэмэгдсэн нь дотоодын даатгалын салбарын тэлэлтийг харуулж байна.

Зураг - 3



Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувийн жин сүүлийн 6 жилд 78,9 хувиас 86,3 хувь болтлоо тогтвортой өссөн байна (Зураг-4).

Зураг - 4



Даатгагчдын нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа эргэлтийн хөрөнгийн бүтцийг сүүлийн 4 жилийн байдлаар харахад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ хамгийн өндөр буюу дунджаар 69,4 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт дунджаар 11,4 хувь, дансны авлага дунджаар 9,1 хувь, бусад эргэлтийн хөрөнгө дунджаар 10,1 хувь орчим байсан бөгөөд 2008 онд эргэлтийн хөрөнгийн бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна (Хүснэгт-1).

Хүснэгт - 1

**Эргэлтийн хөрөнгийн бүтэц**

(сая.төг)

Үзүүлэлтүүд	2005		2006		2007		2008	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12 171.1	67.8	12 510.4	70.8	15 600.1	64.3	22 162.2	74.8
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2 393.7	13.3	1 749.9	9.9	3 065.4	12.6	2 862.2	9.7
Дансны авлага	1 812.7	10.1	1 747.0	9.9	1 979.8	8.2	2 476.0	8.4
Бусад эргэлтийн хөрөнгө	1 565.7	8.7	1 675.2	9.5	3 625.2	14.9	2 131.7	7.2
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>17 943.2</b>	<b>100.0</b>	<b>17 682.5</b>	<b>100.0</b>	<b>24 270.5</b>	<b>100.0</b>	<b>29 632.1</b>	<b>100.0</b>

2008 онд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудыг хөрөнгийн хэмжээгээр жагсаахад “Монгол даатгал” ХХК 11,8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 34,5 хувийг эзэлж даатгалын салбарыг хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байгаа бол “Нийслэл даатгал” ХХК 0,6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт зах зээлийн 1,9 хувийг эзэлж байна (Хүснэгт-2).

Хүснэгт – 2

### Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ

№	Даатгалын компаниудын нэрс	Нийт хөрөнгийн хэмжээ/сая.төг/	Эзлэх хувь
1	Монгол даатгал	11 854.6	34.5
2	Бодь даатгал	3 047.1	8.9
3	Прайм женерал даатгал	2 469.4	7.2
4	Миг даатгал	2 278.8	6.6
5	Ард даатгал	2 045.8	6.0
6	Номин даатгал	1 786.0	5.2
7	Түшиг даатгал	1 526.8	4.4
8	Практикал даатгал	1 515.6	4.4
9	УБ даатгал	1 165.0	3.4
10	Улаанбаатар хотын даатгал	1 272.8	3.7
11	Нэйшнл лайф даатгал	1 121.1	3.3
12	Мөнх даатгал	953.8	2.8
13	Ган зам даатгал	945.0	2.8
14	Монгол траст холдинг даатгал	915.1	2.7
15	Жонон даатгал	792.3	2.3
16	Нийслэл даатгал	641.0	1.9
	<b>СИСТЕМИЙН НИЙТ ДҮН</b>	<b>34 330.2</b>	<b>100.0</b>

Өнгөрөгч 2007 онд даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр зэрэгцүүлэхэд эхний тавд “Монгол даатгал”, “Бодь даатгал”, “Миг даатгал”, “Ард даатгал”, “Прайм женерал даатгал” ХХК-иуд орж байсан бол 2008 онд “Прайм женерал даатгал” ХХК-ийн нийт хөрөнгө 59,7 хувиар буюу 0,9 тэрбум төгрөгөөр өсч системийн хэмжээнд 3-рт орсон байна. “Прайм женерал даатгал” ХХК-ийн нийт хөрөнгийн хэмжээ өссөн гол шалтгаан нь энэ онд тайлант үеийн ашиг 9,7 дахин буюу 227,6 сая төгрөгөөр, нэмж төлөгдсөн капитал 130,0 сая төгрөгөөр нэмэгдсэн болон банкнаас 200 сая төгрөгийн зээл авсан зэрэгтэй холбоотой байна.

### III. ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт хөрөнгөнд эзэмшигчдийн өмч, даатгалын нөөц сан, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 4 жилийн байдлаар харахад 2005-2007 онуудад эзэмшигчдийн өмч дунджаар 37,2 хувь, нөөцийн сан 56,7 хувь, нийт өр төлбөр 6,1 хувийг тус тус эзэлж байсан бол 2008 онд энэхүү бүтцэд нилээд өөрчлөлт гарч нөөцийн сан 43,8 хувь болж 18,9 пунктээр буурч, харин нийт өр төлбөр 18,9 пунктээр өссөн байна (Зураг-5). Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 241 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагын мэдээллийн нэгдсэн сангийн журам”-ын хавсралтын дагуу орлогод тооцоогүй

хураамжийн нөөцийн санг балансын нөөцийн сангийн хэсгээс хасч, өр төлбөр хэсэг дэх урьдчилж орсон орлогоор бүртгэхээр болсонтой холбоотой байна.

Зураг - 5



Тайлант хугацаанд даатгалын салбарын хуримтлагдсан алдагдал 102,9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 200,5 сая төгрөгөөр буюу 2.9 дахин буурсан нь тайлангийн үеийн ашиг 9,5 дахин буюу 744,3 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. 2008 онд ихэнх даатгалын компанийн тайлант үеийн ашиг өндөр хувиар өссөн байна. Тухайлбал, “Практикал даатгал” ХХК-ийх 1857,7 дахин, “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийх 2,6 дахин, “Монгол траст холдинг даатгал” ХХК-ийнх 3,8 дахин өссөн байна.

#### IV. ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН АШИГТ АЖИЛЛАГАА

Тайлант хугацаанд даатгалын салбарт 21,6 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсноос 4,5 тэрбум төгрөг буюу 20,8 хувийг давхар даатгалын хураамжинд, 0,1 тэрбум төгрөгийг буюу 1,4 хувийг буцаасан даатгалын хураамжинд өгч, 16,9 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна. Энэхүү даатгалын цэвэр хураамжийн 55,6 хувь буюу 9,4 тэрбум төгрөгийг орлогод тооцсон хураамжаар тооцож, үлдэх 44,4 хувь буюу 7,5 тэрбум төгрөгийг орлогод тооцоогүй хураамжийн нөөцөд бүртгэсэн байна.

2008 онд “Монгол даатгал”, “Нэйшнл лайф даатгал”, “Нийслэл даатгал” ХХК-иуд 3,1-865,6 сая төгрөгийн тайлант хугацааны алдагдалтай ажилласан бол даатгалын салбарын хэмжээгээр 834,9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн тухайд үйл ажиллагаагаа шинээр эхэлж байгаатай холбоотой алдагдал хүлээж байгаа бол “Монгол даатгал” ХХК-ийн хувьд зардлын бүртгэлийн аргачлал, компанийн үйл ажиллагаа зэрэгтэй холбоотойгоор алдагдалтай ажилласан гэж үзэж болохоор байна. Өнгөрсөн 2007 онд даатгалын компаниудыг тайлант үеийн цэвэр ашгийн дүнгээр жагсаахад “Бодь даатгал”,

“Номин даатгал”, “Ард даатгал” ХХК-иуд эхний гуравт (Хүснэгт-3) орж байсан бол энэ онд “Практикал даатгал” эхний байранд орж, удаах байруудад “Бодь даатгал”, “Прайм женерал даатгал” ХХК-иуд орсон байна (Хүснэгт-4).

Хүснэгт – 3

**Даатгалын компанийн 2007 оны цэвэр ашиг (алдагдал)**

№	Даатгалын компаниудын нэр	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) (мянган төгрөг)	Эзлэх хувь
1	Бодь даатгал	276,587.1	43.7
2	Номин даатгал	105,731.5	16.7
3	Ард даатгал	84,512.9	13.3
4	Улаанбаатар хотын даатгал	73,197.3	11.6
5	Миг даатгал	63,555.7	10.0
6	Жонон даатгал	45,443.1	7.2
7	Монгол даатгал	38,890.2	6.1
8	УБ даатгал	37,703.3	6.0
9	Ганзам даатгал	29,843.0	4.7
10	Прайм женерал даатгал	23,925.6	3.8
11	Монгол траст холдинг даатгал	18,082.2	2.9
12	Практикал даатгал	208.3	0.0
13	Нийслэл даатгал	(13,948.7)	(2.2)
14	Мөнх даатгал	(62,835.6)	(9.9)
15	Түшиг даатгал	(87,342.2)	(13.8)
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>633,553.4</b>	<b>100.0</b>

Өмнөх оны мөн үеийн жагсаалтаар 12-рт орж байсан “Практикал даатгал” ХХК-ийн цэвэр ашиг 1857,7 дахин өссөн гол шалтгаан нь даатгалын нийт хураамж 2,3 дахин, үүн дотор хөрөнгийн даатгал 16,9 дахин буюу 233,4 сая төгрөгөөр нэмэгдсэн, шинээр орон сууцны болон ачааны даатгал хийсэн, мөн даатгалын орлого нь 4,1 дахин өссөн байхад үйл ажиллагааны зардал нь маш бага буюу 2,5 хувиар өссөн байдал ийм өндөр ашигтай ажиллахад нөлөөлсөн байна.

“Прайм женерал даатгал” ХХК 2007 оны эцэст 10-р байранд орж байсан бол 2008 онд гуравдугаарт жагссан нь энэ онд даатгалын хураамжийн орлогоос илүүтэйгээр хөрөнгө оруулалтын орлого нилээд өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт-4

**Даатгалын компанийн 2008 оны цэвэр ашиг (алдагдал)**


№	Даатгалын компаниудын нэрс	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)/сая.төг/	Эзлэх хувь
1	Практикал даатгал	387.0	46.3
2	Бодь даатгал	335.2	40.1
3	Прайм женерал даатгал	253.8	30.4
4	Миг даатгал	204.4	24.5
5	Улаанбаатар хотын даатгал	188.2	22.5
6	Номин даатгал	138.7	16.6
7	УБ даатгал	115.0	13.8
8	Ард даатгал	113.8	13.6
9	Ган зам даатгал	95.4	11.4
10	Монгол траст холдинг даатгал	68.0	8.1
11	Жонон даатгал	64.6	7.7
12	Түшиг даатгал	19.0	2.3
13	Мөнх даатгал	4.9	0.6
14	Нийслэл даатгал	- 3.1	-0.4
15	Нэйшнл лайф даатгал	- 284.3	-34.0
16	Монгол даатгал	- 865.6	-103.7
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>835.0</b>	<b>100.0</b>

Харин нийт хөрөнгө, даатгалын нийт хураамжийн орлогын хэмжээгээрээ даатгалын зах зээлийг тэргүүлдэг “Монгол даатгал” ХХК 2008 онд 865,6 сая төгрөгийн цэвэр алдагдалтай ажиллаж жагсаалтын 16-д орсон нь тус компани 2007 онд санхүүгийн тайлан гаргахдаа Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын дагуу нийт даатгалын хураамжийн орлогоос орлогод тооцоогүй хураамжид ногдох зардлыг хувь тэнцүүлэн авч үлдэн урьдчилж төлсөн зардалд бүртгэн нийт зардалд оруулж тооцоогүй байж байгаад 2008 оны санхүүгийн тайланд энэ зардлыг зардалд оруулж тооцдог болсонтой холбоотой байна.

**V. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО**

2008 онд даатгалын салбарын хэмжээгээр 21,5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсныг өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлттэй харьцуулахад 27,2 хувиар буюу 4,6 тэрбум төгрөгөөр өсч, сүүлийн 8 жилийн хугацаанд хураамжийн орлогын ерөнхий хандлага тогтвортой өсч ирсэн байна (Зураг-6).





Нийт хураамжийн орлогын энэхүү өсөлтийг даатгалын ангиллаар задлан үзвэл санхүүгийн даатгал хамгийн өндөр буюу 2,0 дахинаар, амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал 64,5 хувиар буюу 1,0 тэрбум төгрөгөөр, эд хөрөнгийн даатгал 28,7 хувиар буюу 3,0 тэрбум төгрөгөөр, хариуцлагын даатгал 6,3 хувиар буюу 0,3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна (Хүснэгт-5). Гэхдээ эдгээр өсөлтүүдээс нийт өсөлтөд хамгийн өндөр нөлөө үзүүлсэн нь эд хөрөнгийн даатгалын өсөлт (65,6 хувь) байгааг доорх хүснэгтээс харж болохоор байна.

Хүснэгт – 5


**Даатгалын хураамжийн орлого**

Даатгалын ангилал	2007 (сая төг)	2008 (сая төг)	Өсөлт/бууралт		Өсөлтийн хувь
			(сая төг)	хувь	
1. Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	1 495.0	2 459.7	964.7	164.5	20.9
2. Эд хөрөнгийн даатгал	10 534.7	13 561.1	3 026.4	128.7	65.6

3. Хариуцлагын даатгал	4 566.4	4 851.8	285.4	106.3	6.2
4. Санхүүгийн даатгал	333.0	666.8	333.8	2.0 дахин	7.2
<b>Дүн</b>	<b>16 929.1</b>	<b>21 539.4</b>	<b>4 610.3</b>	<b>127.2</b>	<b>100.0</b>

Даатгалын нийт хураамжийн орлогын бүтцийг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулахад дийлэнх буюу 60,0 гаруй хувийг эд хөрөнгийн даатгал, 20,0 гаруй хувийг хариуцлагын даатгал, 10-аад хувийг амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал, үлдэх 2,0-3,0 хувийг санхүүгийн даатгал эзэлж байна (Зураг-7).

Зураг-7



Даатгалын компаниудыг 2008 онд олсон даатгалын хураамжийн орлогоор нь харьцуулахад “Монгол даатгал” ХХК 6,9 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олж даатгалын салбарын хэмжээнд олсон хураамжийн орлогын 32,1 хувийг, “Нэйшнл лайф даатгал” ХХК 16,1 сая төгрөгийн хураамжийн орлогоор салбарын хэмжээнд олсон хураамжийн орлогын 0,3 хувийг эзэлсэн байна (Хүснэгт-6).


## Даатгалын хураамжийн орлого

№	Даатгалын компаниудын нэрс	Хураамжийн орлого (сая төг)		Өсөлт, хувиар	Эзлэх хувь /2008 он/
		2007 он	2008 он		
1	Монгол даатгал	6 258.5	6 912.1	110.4	32.1
2	Бодь даатгал	4 280.8	4 883.1	114.1	22.7
3	Миг даатгал	1 325.8	2 110.2	159.2	9.8
4	Номин даатгал	922.0	1 385.9	150.3	6.4
5	Прайм женерал даатгал	1 086.1	1 364.0	125.6	6.3
6	Практикал даатгал	462.4	1 061.7	229.6	4.9
7	Ард даатгал	764.0	1 004.7	131.5	4.7
8	Түшиг даатгал	457.5	819.7	179.2	3.8
9	Мөнх даатгал	263.6	764.8	290.1	3.5
10	Улаанбаатар хотын даатгал	411.4	408.7	99.3	1.9
11	Жонон даатгал	241.2	272.5	113.0	1.3
12	УБ даатгал	176.4	199.2	112.9	0.9
13	Ган зам даатгал	50.6	156.9	310.1	0.7
14	Нийслэл даатгал	92.5	106.4	115.0	0.5
15	Монгол траст холдинг даатгал	136.3	89.5	65.7	0.4
16	Нэйшнл лайф даатгал		16.1		0.1
	<b>ДҮН</b>	<b>16 929.1</b>	<b>21 555.5</b>	<b>127.3</b>	<b>100.0</b>

Даатгалын компаниудын хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Монгол траст холдинг даатгал” ХХК-иас бусад компаниудын хураамжийн орлого өссөн байна.

#### ҮІ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Тайлант хугацаанд даатгалын байгууллагууд нийт 4,5 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон нь 2007 оныхтой харьцуулахад 32,4 хувиар буюу 1,1 тэрбум төгрөгөөр өсч, сүүлийн 8 жилийн хугацаанд нөхөн төлбөрийн ерөнхий хандлага тогтвортой өсч ирсэн байна (Зураг - 8).




Нийт нөхөн төлбөрийн энэхүү өсөлтийг даатгалын ангиллаар задлан үзвэл санхүүгийн даатгал хамгийн өндөр буюу 80,1 хувиар буюу 90,3 сая төгрөгөөр, эд хөрөнгийн даатгал 35,9 хувиар буюу 814,7 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 24,5 хувиар буюу 138,4 сая төгрөгөөр, амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал 17,0 хувиар буюу 72,8 сая төгрөгөөр тус тус өссөн байна (Хүснэгт-7). Гэхдээ эдгээр өсөлтүүдээс нийт өсөлтөд хамгийн өндөр нөлөө үзүүлсэн нь эд хөрөнгийн даатгалын өсөлт (73,0 хувь) байгааг доорх хүснэгтээс харж болохоор байна.

**Даатгалын нөхөн төлбөр**

Даатгалын ангилал	2007 (сая төг)	2008 (сая төг)	Өсөлт/бууралт		Өсөлтийн хувь
			(сая төг)	хувь	
1. Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	427.2	500.0	72.8	117.0	6.5
2. Эд хөрөнгийн даатгал	2 270.9	3 085.6	814.7	135.9	73.0
3. Хариуцлагын даатгал	564.6	703.0	138.4	124.5	12.4
4. Санхүүгийн даатгал	112.8	203.1	90.3	180.1	8.1
<b>Дүн</b>	<b>3 375.5</b>	<b>4 491.7</b>	<b>1 116.2</b>	<b>133.1</b>	<b>100.0</b>

Даатгалын нийт нөхөн төлбөрийн бүтцийг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулахад дунджаар 69,9 хувийг эд хөрөнгийн даатгал, 15,0 хувийг хариуцлагын даатгал, 12,4 хувийг амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал, үлдэх 3,9 хувийг санхүүгийн даатгал эзэлж байна (Зураг -9).

Зураг – 9



Даатгалын компаниудыг 2008 онд олгосон даатгалын нөхөн төлбөрөөр нь харьцуулахад “Монгол даатгал” ХХК 2,1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлж даатгалын салбарын хэмжээнд 47,6 хувийг, “Мөнх даатгал” ХХК 0,4 сая төгрөгийн хураамжийн орлогоор салбарын хэмжээнд олсон хураамжийн орлогын 0,01 хувийг эзэлсэн байна (Хүснэгт-8).

Хүснэгт - 8


**Даатгалын нөхөн төлбөр**

№	Даатгалын компаниудын нэрс	Нөхөн төлбөр (сая төг)		Өсөлт, хувиар	Эзлэх хувь /2008 он/
		2007 он	2008 он		
1	Монгол даатгал	1 778.3	2 138.5	120.3	47.6
2	Номин даатгал	320.2	581.0	181.4	12.9
3	Миг даатгал	301.8	440.5	146.0	9.8
4	Бодь даатгал	179.7	383.4	213.4	8.5

5	Ард даатгал	193.9	238.7	123.1	5.3
6	Прайм женерал даатгал	145.8	187.9	128.9	4.2
7	Түшиг даатгал	90.6	184.7	203.9	4.1
8	Практикал даатгал	79.1	121.6	153.7	2.7
9	Улаанбаатар хотын даатгал	45.4	72.4	159.5	1.6
10	Жонон даатгал	36.2	70.6	195.0	1.6
11	УБ даатгал	27.8	22.8	82.0	0.5
12	Нийслэл даатгал	11.6	21.6	186.2	0.5
13	Монгол траст холдинг даатгал	4.0	18.1	452.5	0.4
14	Ган зам даатгал	3.8	9.3	244.7	0.2
15	Мөнх даатгал	157.4	0.4	0.3	0.0
	<b>ДҮН</b>	<b>3 375.6</b>	<b>4 491.5</b>	133.1	<b>100.0</b>

Даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн ерөнхий хандлагыг сүүлийн 8 жилийн байдлаар зэрэгцүүлэн харахад хураамжийн орлогын өсөлтийн хурд нөхөн төлбөрийн өсөлтийн хурдаас их байж ирсэн бөгөөд энэ 2 үзүүлэлтийн хоорондох зай жил ирэх тусам холдож байгааг доорх графикаас харж болохоор байна (Зураг-10).

Зураг-10



## VII. ДААТГАЛЫН ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ТҮВШИН

Тайлант онд даатгалын хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 30,4 хувь болж 2007 оны мөн үеэс 17,9 пунктээр буурсан байна (Зураг-11).

Зураг-11



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын хохирол нөхөлтийн түвшингээр харьцуулахад 2008 оны байдлаар “Номин даатгал” ХХК хамгийн өндөр буюу 52,5 хувьтай байсан бол “Мөнх даатгал” ХХК хамгийн бага буюу 0,1 хувьтай байна (Хүснэгт-9).

Хүснэгт - 9

### Даатгалын хохирол нөхөлтийн түвшин

№	Даатгалын компаниудын нэрс	Хохирол нөхөлтийн түвшин, хувиар		Өсөлт/бууралт, пунктээр
		2007 он	2008 он	
1	Номин даатгал	63.7	52.5	-11.2
2	Ард даатгал	38.5	39.5	1.0
3	Монгол даатгал	61.2	35.5	-25.7
4	Миг даатгал	69.7	33.7	-36.0
5	Түшиг даатгал	37.8	27.5	-10.3
6	Бодь даатгал	22.9	27.5	4.6
7	Жонон даатгал	20.7	25.8	5.1


8	Нийслэл даатгал	19.2	22.8	3.6
9	Улаанбаатар хотын даатгал	18.7	21.8	3.1
10	Прайм женерал даатгал	26.0	16.9	-9.1
11	Практикал даатгал	34.9	15.4	-19.5
12	Монгол траст холдинг даатгал	5.9	12.6	6.7
13	УБ даатгал	21.9	11.7	-10.2
14	Ган зам даатгал	8.9	10.8	1.9
15	Мөнх даатгал	136.1	0.1	<b>-136.0</b>
	<b>ДҮН</b>	<b>48.3</b>	<b>30.4</b>	<b>-17.9</b>

Даатгалын компаниудын 2008 онд олгосон хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Номин даатгал”, “Монгол даатгал”, “Миг даатгал”, “Түшиг даатгал”, “Прайм женерал даатгал”, “Практикал даатгал”, “УБ даатгал”, “Мөнх даатгал” ХХК-иудын хохирол нөхөлтийн түвшин буурч харин бусад компаниудынх өссөн байна.

### VIII. ДАВХАР ДААТГАЛ

Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй Монгол улсын даатгалын компаниуд даатгалын эрсдэлээ гадаад улсын давхар даатгалын компаниудад даатгуулж байгаа байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар судалж үзэхэд 2007 онд огцом буюу 60,7 хувь өссөн бол 2008 онд бараг өөрчлөлт гараагүй байна (Зураг-12).

Зураг-12





2007 он болон 2008 оны давхар даатгалын хураамжийн бүтцийг даатгалын ангиллаар задлан үзэхэд давхар даатгалын хураамжийн ихэнх хувийг эд хөрөнгийн даатгал, хариуцлагын даатгал эзэлж, өчүүхэн хувийг амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал эзэлдэг нь харагдаж байна (Зураг-13).

Зураг - 13




2008 онд нийт 1,3 сая даатгуулагч даатгалд даатгуулснаас 82,4 хувь буюу 1109,1 мянга нь амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн, 10,7 хувь буюу 144,1 мянга нь хариуцлагын даатгалд, 5,3 хувь буюу 71,2 мянга нь эд хөрөнгийн даатгалд, үлдэх 1,6 хувь буюу 21,3 мянга нь санхүүгийн даатгалд, нийт 5,8 их наяд төгрөгийн даатгалын үнэлгээтэй 520,0 мянган даатгалын объектыг даатгуулсан байна.

## IX. ДҮГНЭЛТ, САНАЛ

2008 оны байдлаарх даатгалын салбарын тоон үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад даатгалын салбар бүхий л талаараа нилээд өргөжин тэлж байгаа дүр зураг харагдаж байна. Даатгалын зах зээлийн хөгжлийн гол үзүүлэлт болсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх даатгалын хураамжийн орлогын хэмжээ 0,35 хувь болсон бөгөөд өмнөх оны мөн үеэс 0,02 пунктээр буурсан нь дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хурдцаас даатгалын хураамжийн орлогын өсөлтийн хурдац бага байгааг харуулж байна (Зураг-14). Энэ үзүүлэлт ОХУ-д 2,25 хувь, БНХАУ-д 0,81 хувьтай байна. Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого Монголд 8000 төгрөг байна. Энэ үзүүлэлт БНХАУ-д 20 ам.доллар, ОХУ-д 56 ам.доллар байна. Тухайлбал, салбарын гол үзүүлэлт болох нийт хөрөнгийн хэмжээ 20,8 хувь буюу 5,9 тэрбум төгрөгөөр, эргэлтийн хөрөнгө 21,8 хувиар, эргэлтийн бус хөрөнгө 14,6 хувиар тус тус өссөн байна. Эргэлтийн бус хөрөнгийн өсөлтөд шинээр тус онд байгуулагдсан амьдралын даатгалын компани болох “Нэйшнл лайф даатгал” компани байгуулагдсан явдал нөлөөлжээ. 2007 онд даатгалын салбарын хэмжээнд нийт 303,4 сая төгрөгийн хуримтлагдсан

алдагдалтай ажиллаж байсан бол 2008 онд 102,8 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажиллаж алдагдлын хэмжээ 200,6 сая төгрөгөөр буюу 66,1 хувиар буурч, системийн хэмжээгээр ашигт ажиллагааны түвшин сайжирсан байна.

Зураг-14



Даатгалын бизнесийн үндсэн орлого болох даатгалын хураамжийн орлого ч мөн адил тайлант хугацаанд нилээд өндөр өсөлттэй буюу 27,2 хувьтай байсан бол нөхөн төлбөр 32,4 хувиар өсч нөхөн төлбөрийн өсөлтийн хурдац даатгалын хураамжийн өсөлтийн хурдацаас өндөр байсан байна. Даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн ерөнхий хандлагыг сүүлийн 8 жилийн байдлаар харахад тогтвортой өсч байсан байна. Тайлант онд даатгалын хохирол нөхөлтийн түвшин 30,4 хувь байгаа бөгөөд энэ үзүүлэлт цаашид тодорхой хэмжээгээр өсөх шаардлагатай юм. Цаашид даатгалын нөхөн төлбөр олголтыг шуурхай, бодитой шийдвэрлэж байх, даатгалын үр ашгийг даатгуулагч иргэдэд ил тод мэдрэгдэхүйц байдлаар даатгалын үйлчилгээг үзүүлж байх нь зүйтэй байна.

2008 онд даатгалын дундаж компаниуд даатгалын зах зээл дээрх үйл ажиллагаагаа эрчимжүүлж, өрсөлдөх болсон нь тэдгээр компаниудын хураамжийн орлогын өндөр өсөлтөөс харагдаж байна. Тухайлбал, “Ган зам даатгал”, “Мөнх даатгал”, “Практикал даатгал”, “Миг даатгал”, “Номин даатгал” ХХК-иудын даатгалын хураамжийн орлого 50,3 хувиас 3,1дахин өссөн байна. Өнөөгийн байдлаар манай улсын даатгалд хамрагдах боломжит зах зээлийн маш өчүүхэн хувь нь даатгалд хамрагдаж байгаа билээ. Иймд цаашид жолоочийн хариуцлагын заавал даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийг даатгах замаар даатгалын хамралтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Даатгалын компаниуд олон улсын давхар даатгалын компаниудтай хамтран ажиллах сонирхолтой болж эхэлж байгаа нь нилээд нааштай үзүүлэлт бөгөөд тайлант хугацаанд шинээр 2 даатгалын компани давхар даатгалын үйл ажиллагаанд оролцож эхэлсэн байна.